

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР

"НИЙСЛЭЛИЙН 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ"
ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2023 оны 06 дугаар сарын 12

Улаанбаатар хот

№	Бодлогын зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Батлагдсан төсөв	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр(сая)	Зорилтот түвшин, үр дүнгийн	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Үнэлгээний тайлбар	Хариуцах байгууллага
---	-----------------	-------------	------------------	------------------	---	-----------------------------	-----------------------	-------------------	--------------------	----------------------

5. TAB. ЗАСАГЛАЛ

1.	5.3. Мэргэшсэн, чадварлаг, иргэндээ үйлчилдэг, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.	5.3.1. Нийслэлийн нутгийн захирагааны байгууллагуудад болон олон улсын чанарын менежментийн тогтолцоо, стандартыг нэвтрүүлсэн байна.	2021-2025	-	-	34	Нийслэлийн нутгийн захирагааны байгууллагуудад чанарын удирдлагын тогтолцоо MNS ISO 9001:2016 стандарт нэвтрүүлэх ажлын хүрээнд нийт 20 байгууллагын дэд ажлын хэсэгт тус газрын 7 албан хаагчид ажиллаж, чанарын Менежментийн тогтолцоог нэвтрүүлэхэд арга зүйгээр ханган ажиллаж байна.	70	-	НЗДТГ ХСХГ
----	--	--	-----------	---	---	----	---	----	---	------------

8. НАЙМ. БҮС ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

2.	8.1. Монгол улсын үндэсний түвшний хөгжлийн бодлоготой нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулж, дагуул хаяа хот, тосгодын хөгжлийг	8.1.7. Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн байна.	2021-2025	-	-	1	2022 оны 10 дугаар сарын 03-ны өдөр ХБХГ-аас 02/3655 тоот бичгээр ирүүлсний дагуу 2023 онд тус ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай төсөв хөрөнгийг тусгувлан, манай байгууллагатай барилга байгууламжийн хяналтын чиглэлд хамтран ажиллахаар болсон. Одоогийн байдлаар дараах ажлууд хийгдсэн. Үүнд: - Багахангай дүүргийн үйлдвэрлэл, технологийн паркийн хэсэгчилсэн	30	-	НХБХГ НМХГ НШУҮИГ ХСХГ
----	---	--	-----------	---	---	---	--	----	---	------------------------

	эрчимжүүлж, хотын төвлөрлийг сааруулах бодлогыг боловсруулна.						ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, - Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн зураг төсөл зэрэг болно. 2. ХХААХҮ-н яам, "Жайка"-н Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран зохион байгуулсан "Үйлдвэрийн хаягдал усны хяналт, бизнесийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээний дүрэм, журам, тогтолцооны талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх" воркшоп-д оролцон санал солилцсон.		
--	---	--	--	--	--	--	---	--	--

9. ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ

3.	9.3 Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд ухаалаг технологийг нэвтрүүлж, нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн сант өргөжүүлэн иргэд, олон нийтэд нээлттэй болгон, тэгш хүртээмжийг нэмэгдүүлнэ.	9.3.1. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд сууринсан газар олгох, барилга барих зөвшөөрлийг иргэд, олон нийтэд нээлттэй болгосон байна.	2021-2025	-	-	1	Монгол улсын Ерөнхий сайдын 2023 оны 01 дүгээр албан даалгавар, "Шил" ажиллагааны хүрээнд нийслэлийн хэмжээнд баригдсан нийт 883 барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан комиссын дүгнэлт, холбогдох гишүүдийн мэдээллийг нэгтгэж info@shilen.gov.mn цахим сайтад байршуулахаар Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлэв. Комиссын үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг нь тус газарт шилжсэн дараах цаг хугацаанд ашиглалт орсон барилгын мэдээллийг нэгтгэсэн. Үүнд: - Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /хуучнаар/ хариуцсан буюу 2009-2012 онд ашиглалтад орсон 155 барилгын мэдээллийг Үндэсний архивын газар дахь баримтаас шүүж, нэгтгэв. - Тус газрын хариуцсан хугацаа буюу 2020-2023 оны хооронд ашиглалтад орсон 728 барилгын мэдээллийг газрын цахим архив, мэдээллийн сангаас шүүж нэгтгэв.	90	-	НХБХГ НГЗБА ХСХГ НМТГ
----	--	--	-----------	---	---	---	--	----	---	-----------------------

							Дээрх ажлын хүрээнд Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах үед комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн хуудас"-ыг зохих шаардлагын дагуу боловсруулж, ажлын хэсэгт хүргүүлсэн.		
4	9.5. Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	9.5.1. Хот төлөвлөх, байгуулах үйл ажиллагаанд болон нийгмийн үйлчилгээний барилгын стандартыг мөрдүүлдэг тогтолцоог бий болгоно.	Хот төлөвлөх, байгуулах стандартыг мөрдүүлдэг тогтолцоог бий болгоно.	2021-2025	Хот төлөв лөх, байгуулах стандарт 45, Төрийн болон нийгмийн үйлчилгээний барилга 213	Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаанд мөрдөгдөх стандартын шаардлагуудыг хангуулахаар 2022 онд 9 бүлгийн 38, 2023 онд 7 бүлгийн 14 хотын стандартыг боловсруулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулсан. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамжаар батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу дүүрэг бүрт ажлын хэсэг байгуулан хотын стандартыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулж, 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар үндсэн 4 чиглэлээр дараах үзүүлэлт бүхий ажлыг гүйцэтгэсэн байна. Үүнд: - Хотын стандартын талаарх мэдлэг, ойлголт өгөх сургалтад нийт 1261 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулав. - Хотын стандартын хэрэгжилтийн байдалд Барилга, дэд бүтэц, барилгын гадна орчны аюулгүй байдлын чиглэлээр барилга угсралтын ажилд хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтад нийт 155 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгаж ажиллав.	90	-	ХСХГ

							Орчны аюулгүй байдлын 17 төрлийн судалгааг нэгтгэн боловсруулж байна.			
5		9.5.3 Хотын стандартын дагуу орчны аюулгүй байдлын хяналт шалгалтыг сайжруулж, иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулсан байна.	2021-2025	-	-		Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамжаар “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай” нэгдсэн арга хэмжээний удирдамж, хяналт шалгалтын нэгдсэн ажлын төлөвлөгөөний хүрээнд 9 дүүргийн хэмжээнд хяналт шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллан иргэдийн амьдрах орчинд эрсдэл учруулж болзошгүй зөрчлүүдийг илрүүлж улсын байцаагчийн зөвлөмж 120, зөрчил дутагдал арилгах тухай мэдэгдэл 93, дутагдал арилгуулах албан шаардлага 42 хүргүүлсэн. Мөн орчны аюулгүй байдлыг алдагдуулсан 10 ААНБ-ын үйл ажиллагааг зогсоож ажилласан.	50		
Дундаж биелэлт									66%	

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Э.ДАВААХАТАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Н.ДААРИЙМАА

